

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 2 сарын 15 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

Монгол улсын компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.10 дахь заалт, Ногдол ашгийн журмын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны цэвэр ашиг болох 4,617,347,556.16 төгрөгөөс компанийн хувьцаа эзэмшигчдэд 2,600,000,000 төгрөгийн ногдол ашиг хуваарилсугай.
2. Нэгж хувьцаанд ногдох хэмжээг 1.30 /нэг төгрөг гучин мөнгө/ төгрөгөөр тогтоосугай.
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрөөр, ногдол ашиг төлөх сүүлийн өдрийг 2026 оны 4-р сарын 30-ны өдрөөр тус тус тогтоосугай.
4. Ногдол ашгаас холбогдох хууль тогтоомжийн дагуу Хувь хүний орлогын албан татвар болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, жижиг хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар дамжуулан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг компанийн данснаас хувьцаа эзэмшигчдийн дансанд олгосугай.
5. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийн талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг гүйцэтгэх захирал Б.Бадамцэцэгт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 2 сарын 15 өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

ЗЭЭЛИЙН ЭРХ НЭЭХ ГЭРЭЭГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дахь заалт, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн “Зээлийн эрх нээх гэрээ”-г хавсралт 1-ээр, баталсугай.
2. Компанийн “Зээлийн эрх нээх гэрээ”-г 2026 оны 3-р сарын 2-ны өдрөөс тус тус мөрдөн ажиллахыг Гүйцэтгэх захирал Б.Бадамцэцэг, Салбарын захирал Ц.Билэг-Өрнөх, Салбарын захирал М.Уянга нарт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 2 сарын 15 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗУУЧЛАЛЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.2 болон 80 дугаар зүйлийн 80.7, 89 дүгээр зүйлийн 89.1.1 болон Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.19-д заасныг үндэслэн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Хөрөнгө оруулалт татахтай холбогдуулан “Сикап ҮЦК” ХХК-тай “Хөрөнгө оруулалтын зуучлалын гэрээ” байгуулсугай.
2. Компанийг төлөөлөн “Хөрөнгө оруулалтын зуучлалын гэрээ” байгуулах эрхийг гүйцэтгэх захирал Б.Бадамцэцэгт олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ